

Батлав. Сургалт, цахим шилжилтийн газрын захирал

Н.Эрдэнэхүү



ШУТИС-ийн оюутнуудыг эрүүл мэндийн даатгалд хамруулах удирдамж

2023-08-14

1. Зорилго

- Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 4.2-т заасны дагуу Монгол улсын иргэн эрүүл мэндийн улмаас учирч болзошгүй санхүүгийн эрсдэлээ хуваалцах зорилгоор эрүүл мэндийн албан журмын даатгалд заавал даатгуулах үүргийг хэрэгжүүлэх;
- Эрүүл мэндийн даатгалын хуулийн 6-р зүйлийн 6.1.9. заалт, 8-р зүйлийн 8.3.3 заалтын дагуу их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн суралцагчийг эрүүл мэндийн даатгалд хамруулах заалтыг хэрэгжүүлэх;
- Боловсрол шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2023/07/31-ны өдрийн А/273, А/314 тушаалын дагуу ШУТИС-ийн нийт оюутнуудыг эрүүл мэндийн даатгалд хамруулж, 2023 оны 11 дүгээр сарын 01-ний дотор зохион байгуулагдах эрт илрүүлэг, үзлэгт үнэ төлбөргүй хамруулах бэлтгэл ажлыг хангах.

2. Зохион байгуулагч

Эрүүл мэндийн яам, ШУТИС-ийн Эрүүл мэндийн төв, бүрэлдэхүүн сургуулийн захиргаа

3. Хугацаа

Шинэ элсэгчдийг 2023 оны 08 сарын 16-наас 09 сарын 01 хүртэл, үргэлжлүүлэн суралцагсдыг 2023 оны 08 сарын 16-наас 09 сарын 25 хүртэл хугацаанд даатгалд бүрэн хамруулна.

4. Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээ, төлбөрийн хэмжээ

Оюутан эрүүл мэндийн даатгалд хамрагдсанаар дараах үйлчилгээг авах боломжтой. Үүнд:

- Эрт илрүүлэгийн үзлэг шинжилгээнд үнэ төлбөргүй хамрагдах;
- ЭМДЕГ-тай гэрээтэй улсын болон хувийн хэвшлийн 2400 гаруй эрүүл мэндийн байгууллагаас 16 багц төрлийн тусламж, үйлчилгээг ЭМД-ын сангаас 70-100 хувь хөнгөлүүлэн авах;
- Ерөнхий нэршлийн 159, худалдааны нэршлийн 648 эмийг 30-100 хувийн хөнгөлөлттэй үнээр авах;
- Бусад нэмэлт үйлчилгээ.

Даатгалын төлбөр хэмжээ:

Оюутан ЭМД-ын шимтгэлээ өөрөө хариуцан төлөх бөгөөд сард тухайн жилийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1 хувьтай тэнцэх төлбөрийг төлнө. Сүүлийн 5 жилд дараах байдлаар даатгалын төлбөрийг тооцно.

д/д	Он	1 сард төлөх дүн /Төгрөг/	1 жилд төлөх дүн /Төгрөг/
1	2019	3200	38400
2	2020	4200	50400
3	2021	4200	50400
4	2022	4200	50400
5	2023	5500	66000

5. Эрүүл мэндийн даатгалд хамруулах үйл ажиллагаа

ШУТИС-ийн эрүүл мэндийн төв, бүрэлдэхүүн сургуулийн захиргаатай хамтран оюутнуудыг эрүүл мэндийн даатгалд хамруулах, хяналт тавих үйл ажиллагааг зохион байгуулна. Ингэхдээ дараах зарчмыг баримтална. Үүнд:

- Шинэ элсэгчийн хувьд 19 нас хүрсэн сараас эхлэн даатгалын төлбөрөө тооцож төлнө.
- Үргэлжлүүлэн суралцаж байгаа оюутнуудын хувьд 2019 оны 01 сараас 2023 оны 12 сарыг дуустал хугацааны ЭМД-ын төлбөрийг төлнө.
- Шинээр элсэгч суралцах гэрээ байгуулахаар сургуульд дээр ирэхдээ ЭМД төлсөн нотлох баримтаа авч ирэх ба сургалтын албанд баримтыг шалган суралцах гэрээ байгуулна.
- Оюутан эрүүл мэндийн даатгал төлөлтөө шалгахдаа <http://emd.gov.mn/rd/search> цахим хаягаар хандаж өөрийн регистрийн дугаараа оруулах эсвэл дараах QR кодыг утасны камераар уншуулан нэвтэрч болно.



- E-Varimt аппликейшн ашиглан ЭМД-аа төлөх тохиолдолд дараах алхамуудыг баримтлах ба даатгуулагчийн төлсөн төлбөр 15-30 минутад баталгаажна.
 - Алхам 1 : Гар утасныхаа Appstore болон Playstore-оос E-Varimt гэж хайн UPDATE хийж, нэвтрэх.
 - Алхам 2: Үйлчилгээ цэснээс “Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар” хэсгийг сонгох.
 - Алхам 3: Даатгуулагчийн төрлөө сонгох.
 - Алхам 4 : Шимтгэлээ сар, хагас жил, бүтэн жилээр төлөх сонголтуудаас сонгох.
 - Алхам 5 : Өөрийн регистрийн дугаар болон аймаг, дүүргээ сонгон баталгаажуулах.
 - Алхам 6 : Хүснэгтээс шимтгэл төлөх саруудаа сонгох
 - Алхам 7 : Төлбөрийн боломжуудаас сонгож төлөлт хийнэ.
- ЭМД-аа дансаар төлөх тохиолдолд дараах дансуудын аль нэгэнд шилжүүлж болно. Ингэхдээ гүйлгээний утганд овог нэр, регистрээ бичнэ. Дансаар төлөх тохиолдолд төлбөр 24 цагт баталгаажна.
 - СБД -ийн ЭМД-ийн данс 5009209225
 - ХУД-ийн ЭМД-ийн данс 5622251475
 - БЗД-ийн ЭМД-ийн данс 5751203114

6. Үр дүнг тайлагнах

Оюутнуудыг эрүүл мэндийн даатгал хамруулах үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулсан тухай үр дүнгийн тайланг Эрүүл мэндийн төв гаргаж 2023 оны 10 сарын 01-ны дотор тайлагнана. Үр дүнгээс хамаарч үйл ажиллагааг дахин төлөвлөж, хэрэгжүүлж болно.